



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар Б/24

Баян-Овоо сум

□ С.Номин-Эрдэнийг ажилд томилох тухай □

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, (Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ)-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сандагсүрэнгийн Номин-Эрдэнийг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дотуур байрын үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсугай.

2. С.Номин-Эрдэнийн сарын үндсэн цалинг ТҮ-1 зэрэглэлээр тогтоон 954,000 (есөн зуун тавин дөрвөн мянга) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д, ажил үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аж ахуйн нярав (Т.Хэрлэнчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ *Ч.Болормаа* Ч.БОЛОРМАА

